



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ОРХОН АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 05

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаал, Нийцлийн аудитын түр журмын 9.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУЕА-ын 2017 оны А/12 тоот тушаал, УАГ-ын нэгдсэн удирдамж, байгууллагын 2017 оны бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийгдсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт” нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөрчлийн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, Баян-Өндөр сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Жаргалант сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтэд хяналт тавин ажиллахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, нийцлийн аудитын ахлах шинжээч /Д.Цогбадрах/, шинжээч /О.Дашжамц/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗРЫН ХАРЬЯА
ОРХОН АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт



ОНХС-ийн төлөвлөлтийг хийхдээ төсөл арга хэмжээг иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн санал авч эрэмбэлээгүй, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаагүй байна.

**Орхон аймаг
2017 он**

**Аудитын
тайланг
бэлтгэсэн:**

**Орхон аймгийн
Аудитын газар**

Дарга:

Ц.Нармандах

Аудитын
менежер:

Б.Эрдэнэ

Ахлах
шинжээч

Д.Цогбадрах

Шинжээч:

О.Дашжамц

2017 оны 4
дүгээр сар

Уг тайланг Орхон
аймгийн Аудитын
газрын цахим
хуудаснаас үзнэ
үү.

Аудитын
тайлантай
холбоотой
асуудлаар нэмж,
тодруулах, лавлах
зүйл байвал
70357955,
70350757
дугаарын утас,
70359826
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Орхон
аймгийн Аудитын
газар

Баян-Өндөр сум,
Хүрэнбулаг баг,
Нутгийн
удирдлагын ордон

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт,
аудит хийх үндэслэл:

**БҮЛЭГ 1. ОНХС-н хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд
заасны дагуу төлөвлөөгүй ч хуулийн дагуу бүрдүүлж,.....6**
хуваарилсан байна.

1.1 ОНХС болон аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг
батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөөгүй байна.6

1.2 Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн
төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож
төлөвлөөгүй байна.6-7

1.3 Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан төрөл
тус бүрээр бүрдүүлсэн байна.7-9

1.4 Аймгийн ОНХС-аас олгосон шилжүүлгийг батлагдсан
хуваарийн дагуу олгосон байна.9-10

**БҮЛЭГ 2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга
хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөн баталж,10**
гүйцэтгээгүй байна.

2.1 ОНХСангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого,
тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн ч, урьдчилсан
саналын жагсаалтыг бэлтгээгүй байна.10-11

2.2 ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг иргэдэд
нээлттэй хэлэлцүүлэн авсан санал, эрэмбэ нь хууль журмын дагуу
хийгдээгүй байна.11-12

2.3 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь заалтыг
хангасан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.12-13

2.4 Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан- байна.13-14

2.5 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүрэгт
багтаагүй төсөл, арга хэмжээнд 426.2 сая төгрөг, өөр эх
үүсвэртэй давхардуулан 1196.2 сая төгрөгийг тус тус ОНХС-аас
зарцуулсан байна.15

2.6 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг
тавьж, ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан
санхүүжилтийг олгосон байна.15-17

2.7 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг “Нягтлан
бодох бүртгэлийн тухай” хуулийн дагуу бүртгэл тайланд
тусгасан байна.17

**БҮЛЭГ 3. ОНХСангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг
хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, хэрэгжилтийг
зааврын дагуу тайлагнаагүй байна.17**

3.1 ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэний нийгмийн
байгууллагууд болон дотоод аудитын алба ОНХС-ийн
хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.17-18

3.2 ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн
сангийн заавар”-ын дагуу хүргүүлээгүй, тайланд дүн шинжилгээ
хийгээгүй байна.18

3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн
мэдээллийг зааврын дагуу мэдээлээгүй байна.18-19

3.4 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь бусад хууль
тогтоомжтой зөрчилдөөгүй байна.19

3.5 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж 100 хувь, албан шаардлага
90.1 хувийн биелэлттэй байна.20-21

Дүгнэлт

Холбогдох байгууллагын санал

Хавсралтууд

Тэргүүлэх аудиторын тушаал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АЗДТГ	Аймгийн Засаг Даргын Тамгын Газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчидийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХББЗА-ОНӨҮГ	Хот байгуулалт барилга захиалагчийн алба-Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ХЗА	Хотын захирагчийн алба
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТББ	Төрийн бус байгууллага
ДТС	Дулаан түгээх сүлжээ
ӨХГ	Өмчийн харилцааны газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, ЯАГ-ын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийх аудитын төлөвлөгөөг тус тус үндэслэн Үндэсний аудитын газрын харьяа Орхон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

2. Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийнэ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх;

3. Аудитын хамрах хүрээ:

Аудитад Орон нутгийн хөгжлийн сан, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг Даргын Тамгын Газар, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, Хотын захирагчийн алба, Хот байгуулалт барилга захиалагчийн алба, баг хороодын Засаг дарга, Иргэдийн нийтийн хурлыг хамруулж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт зэргийг авч үзлээ.

4. Аудитын арга зүй:

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, шалгах хуудас боловсруулах зэрэг аудитын арга зүйг ашиглахаас гадна Төрийн хяналт, шалгалтын стандарт, нийцлийн аудитын гарын авлагад дурдсан аудитын арга зүйг мөрдөж аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, санал боловсрууллаа.

5. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Төсвийн тухай хууль

- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

6. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Орхон аймгийн тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитыг ахлах шинжээч Д.Цогбадрах, шинжээч О.Дашжамц нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. /хаяг: orkhon.audit.mn, утас: 70357955/

7. Аудитын тайлан, баталгаажуулалт: Аудитыг 2017 оны 02 дугаар сарын 15-нд эхэлж, талбарын ажлыг 04 дүгээр сарын 05-нд дуусгаж, аудитын тайланг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Тэргүүлэх аудиторроор баталгаажуулан 2016 оны 05 сарын 01-ны дотор ҮАГ-т хүргүүллээ.

Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт судалгаа, холбогдох байгууллагын саналыг тусгалаа.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолд “Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Монгол улсын 2016 оны Төсвийн тухай хуульд 2016 оны 09 сарын 09-д орсон тодотголоор улсын төсөв дутуу бүрдсэнтэй холбоотойгоор Орхон аймгийн ОНХС-д олгох орлогын хэмжээг 3562.0 сая болгон 1328.6 сая төгрөгөөр бууруулан, ОНХНС-д төвлөрүүлэх орлогын хэмжээг 4862.2 сая төгрөг болгон 209.6 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

Дээрх төсвийн тодотголтой уялдуулан аймгийн ИТХ нь 2016 оны 10-р сарын 28-ны өдрийн 02-р тогтоолоор ОНХНСангаас олгох орлогын хэмжээг 3562.0 сая төгрөг, орон нутгийн үндсэн тэнцлийн ашиг 4236.8 сая төгрөг, хандивын орлого 16.0 сая төгрөг, нийт орлогыг 7814.8 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 4862.2 сая төгрөгөөр тус тус тодотгон баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 10 сарын 28-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 36.5 хувь буюу 2853.6 сая төгрөгийг аймагт, 47.5 хувь буюу 3717.1 сая төгрөгийг Баян-өндөр суманд, 16 хувь буюу 1244.0 сая төгрөгийг Жаргалант суманд тус тус олгохоор хуваарилан баталсан байна.

Орхон аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2853.7 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээ, Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 3717.1 сая төгрөгийн 102 төсөл арга хэмжээ, Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр 1244.0 сая төгрөгийн 40 төсөл арга хэмжээг зохион байгуулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд шинээр хэрэгжүүлсэн нийт 156 төсөл, арга хэмжээний 6.5 хувь буюу 10 ажлыг нээлттэй тендер, 46.2 хувь буюу 72 ажлыг харьцуулалтын аргаар, 40.2 хувь буюу 55 ажлыг шууд гэрээ байгуулах аргаар хэрэгжүүлж, 12.1 хувь буюу 19 ажил нь худалдан авах ажиллагаа зохион байгуулах шаардлагагүй төсөл, хөтөлбөрүүд байна.

Аймгийн ОНХС-аас 116.0 сая төгрөгийг аймгийн баяр наадмын зардалд зарцуулжээ.

Өмнөх оны аудитаар 2139.0 сая төгрөгийн 11 албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлсэн.

Бүлэг.1. ОНХС-н хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөөгүй ч хуулийн дагуу бүрдүүлж, хуваарилсан байна.

1.1 ОНХНС болон аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөөгүй байна.

Монгол улсын 2016 оны Төсвийн тухай хуулиар Орхон аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 4890.6 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх орлогын хэмжээг 5071.8 сая төгрөгөөр баталжээ .

2016 оны Төсвийн тухай хуульд 2016 оны 09 сарын 09-д орсон тодотголоор улсын төсөв дутуу бүрдсэнтэй холбоотойгоор Орхон аймгийн ОНХС-д олгох орлогын хэмжээг 3562.0 сая болгон 1328.6 сая төгрөгөөр бууруулан, ОНХНС-д төвлөрүүлэх орлогын хэмжээг 4862.2 сая төгрөг болгон 209.6 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

ОНХНС-аас ОНХС-д олгох шилжүүлгийн хуваарилалтаар тооцоолж үзэхэд манай аймгийн итгэлцүүр 3.625% байна.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс “2016 оны төсвийн төсөл”-ийг Сангийн яаманд хүргүүлэхдээ ОНХС-ийн орлогын талаарх саналыг тусгаагүй, сумдын ОНХС-д хуваарилах тооцоолол, төлөвлөлтийг хийгээгүй, сумдад төсвийн төсөл боловсруулах удирдамжийг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан журмын 3.2-т зааснаар хүргүүлээгүй нь ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлал, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1, 12.2.5г, 12.2.5д, 12.2.7-д заасныг мөрдөж ажиллаагүй байна.

1.2 Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна.


Аймгийн СТСХ болон сумдын Санхүүгийн албад нь 2016 оны ОНХС-ийн эх үүсвэрийг огт төлөвлөөгүй нь Төсвийн тухай хуулийн 12.1.4, 27.1.1, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.2.2, 2.2.3, 2.2.4, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тогтоол “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1, 6.2 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Дээрх хууль, журмын дагуу төлөвлөлт хийн, санхүүжүүлсэн бол аймгийн нийт ОНХС-ын орлогоос 3572.0 сая төгрөг нь Баян-Өндөр суманд, 1389.1 сая төгрөг нь Жаргалант суманд хуваарилагдах байжээ.

Гэвч сумд төлөвлөлт хийгээгүй, аймгаас шилжүүлсэн санхүүжилтийг нь авсан учир аймгийн ОНХС-аас Баян-Өндөр суманд 3717.1 сая төгрөг, Жаргалант суманд 1244.0 сая төгрөгийн санхүүжилт буюу 145.1 сая төгрөгний зөрүүтэй санхүүжилтүүд олгогджээ.

1.3. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан төрөл тус бүрээр бүрдүүлсэн байна.

Сүүлийн 3 жилийн ОНХНС-аас Орхон аймгийн ОНХС-д олгосон орлогын хэмжээ болон, ОНХНС-д төвлөрүүлэх орлогын хэмжээг графикаар харьцуулвал:



Уг графикаас харвал сүүлийн жилүүдэд ОНХНС-аас аймагт олгох орлогын дүн тогтмол буурсан буюу 2 жилийн дотор 5893.3 сая төгрөгөөр, аймгаас ОНХНС-д төвлөрүүлэх орлогын хэмжээ 4172.0 сая төгрөгөөр өссөн харагдаж байна.

Улсын төсөвт тодотгол хийгдсэнтэй уялдуулан аймгийн ИТХ-ийн 2016 оны 10-р сарын 28-ны өдрийн 02-р тогтоолоор ОНХНСангаас олгох орлогын хэмжээг 3562.0 сая төгрөг, орон нутгийн үндсэн тэнцлийн ашиг 4236.8 сая төгрөг, хандивын орлого 16.0 сая төгрөг, нийт орлогыг 7814.8 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 4862.2 сая төгрөгөөр тус тус тодотгон баталсан байна.

Уг тодотголоор санхүүжилт багассан тул аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн Түрээсийн орон сууц худалдан авах ажлын санхүүжилтийг 758.5 сая төгрөгөөр дутуу олгон, Баян-Өндөр сумын ОНХС-аар гүйцэтгэх байсан Эрдэнэ багийн ахуйн үйлчилгээний төвийн барилгын ажил нь зураг төсөв нь батлагдаагүй, хийгдэж эхлээгүй байсан учир хасагдсан байна.

Улмаар Баян-Өндөр суманд хуваарилах санхүүжилтийн хэмжээг 3717.1 сая төгрөг, Жаргалант суманд хуваарилах санхүүжилтийн хэмжээг 1244.0 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

Харин Жаргалант сумын ИТХ-ын 01-р тогтоолд ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх төсөл, арга хэмжээнд 916.0 сая төгрөг баталсан нь аймгийн ИТХ-аар баталсан орлогын шилжүүлэгтэй зөрүүтэй байна.

/сая.төг/

№	Аймаг сумын нэр	2016 оны Төсвийн тухай хуулиар баталсан дүн		ИТХ-аар баталсан дүн		Зөрүү	
		ОНХНС-аас олгох орлого	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	ОНХНС-аас олгох орлого	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	ОНХНС- аас олгох орлого	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого
1	Орхон аймаг	3562.0	4862.6	3562.0	4862.6	-	-

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 4862.6 сая төгрөгийг 2016 оны 12-р сарын 25-ны өдөр бүрэн төвлөрүүлж батлагдсан төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байна.

ОНХНСангаас аймагт олгох батлагдсан орлогын шилжүүлгийг 100 хувь буюу 3562.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

/сая.төг/

№	Аймаг сумын нэр	ОНХНСангаас олгосон санхүүжилт			
		Батлагдсан дүн	СЯ-аас санхүүжүүлсэн дүн	Зөрүү	Санхүүжилтийн хувь
1	Орхон аймаг	3562.0	3562.0	-	100%

Гүйцэтгэлээр ОНХНСангаас 3562.0 сая төгрөг, орон нутгийн үндсэн тэнцлийн ашгаас 4236.8 сая төгрөг, өмнөх оны үлдэгдэл 121.1 сая төгрөг, хандиваар 21.9 сая төгрөг, нийт 7941.9 сая төгрөг орон нутгийн хөгжлийн сангийн 210052400 тоот дансанд төвлөрсөн байна.

Мөн аймаг, сумдын ОНХС-д орон нутгаас төвлөрүүлсэн орлогыг харуулвал:

/сая.төг/

Орон нутгаас орсон орлого

№	Аймаг сумын нэр	Оны эхний үлдэгдэл	Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн	Хандив	Бусад	Нийт орлого
1	Орхон аймаг	25.3	1640.0	-	21.9	-	1687.2
2	Баян-Өндөр сум	93.6	2268.8	-	-	-	2362.4
3	Жаргалант сум	2.2	328.0	-	-	-	330.2
	Нийт дүн	121.1	4236.8	-	21.9	-	4379.8

ОНХСангийн 2016 оны орлогын эх үүсвэрийн 44.9 хувийг ОНХНСангийн шилжүүлгээс, 53.3 хувийг орон нутгийн үндсэн тэнцлийн ашгаас, 0.3 хувийг бусад эх үүсвэрээс, 1.5 хувийг өмнөх оны үлдэгдэл санхүүжилтаас тус тус бүрдүүлжээ.

Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 60.2.1-т “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг”, 60.2.3-т “орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг хасч үлдэх хэсэг”, 60.2.5-т “тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж” гэсэн заалтуудтай нийцүүлэн бүрдүүлсэн байна.

1.4 Аймгийн ОНХС-ийн шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна.

ОНХНСангаас орсон санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 59.2-т “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна” гэж заасны дагуу аймгийн ИТХ-ын 2016 оны 10 сарын 28-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 36.5 хувь буюу 2853.6 сая төгрөгийг аймагт, 47.5 хувь буюу 3717.1 сая төгрөгийг Баян-өндөр суманд, 16.0 хувь буюу 1244.0 сая төгрөгийг Жаргалант суманд тус тус олгохоор хуваарилан баталсан байна.

/сая.төг/

№	Аймаг сумын нэр	АИТХ-аар баталсан дүн	Санхүүжүүлсэн дүн	Зөрүү	Санхүүжилтийн хувь
1	Аймаг	2853.7	2853.7	-	36.5
2	Баян-Өндөр сум	3717.1	3717.1	-	47.5
3	Жаргалант сум	1244.0	1244.0	-	16.0
	Нийт дүн	7814.8	7814.8	-	100

Орон нутгийн хөгжлийн сангаас сумдад олгох санхүүжилтийг Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан аргачлалаар 4 хүчин зүйлийг харгалзан хуваарилахаар заасан байх боловч орон нутгийн онцлогоос шалтгаалан уг тогтоолын 9.4-т “Энэ аргачлалын 3.2.1-д заасан орон нутгийн хөгжлийн индексийг сум, дүүргийн түвшинд үнэн зөв, бодитой байдлаар гаргах боломжтой болох хүртэлх хугацаанд уг индексэд харгалзах 25 хувийг аргачлалын 3.2.2-3.2.4-т заасан үзүүлэлтүүдэд тэнцүү хуваарилах байдлаар орлуулан хэрэглэж болно” гэсэн заалттай нийцүүлэн 3 үзүүлэлтэд 33.3%-иар хуваан хэрэглэсэн байна.

Уг аргаар тооцоолоход Баян-Өндөр суманд 72%, Жаргалант суманд 28% ноогдохоор байсан бол 2 суманд хуваарилсан 4961.1 сая төгрөгний 74.9% Баян-Өндөр суманд, 25.1% нь Жаргалант суманд хуваарилагдсан байна.

Улмаар сумдад доорх зөрүүтэй санхүүжилт орсон байна.

/сая төгрөг/

№	Аймаг сумын нэр	Хуваарилагдах ёстой дүн	Хуваарилагдсан дүн	Зөрүү	Санхүүжилтийн хувь
2	Баян-Өндөр сум	3572.0	3717.1	145.1	74.9
3	Жаргалант сум	1389.1	1244.0	(145.1)	25.1
	Нийт дүн	4961.1	4961.1	0	100

Дээрх хүснэгтээр Жаргалант суманд олгогдох ёстой байсан 145.1 сая төгрөг Баян-Өндөр суманд илүү олгогдсон харагдаж байна.

Бүлэг.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөн баталж, гүйцэтгээгүй байна.

2.1. ОНХСангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн ч, урьдчилсан саналын жагсаалтыг бэлтгээгүй байна.

2016 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд нь аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, Орхон аймгийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй нийцэж байгаа хэдий ч ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулаагүй байна.

Баян-Өндөр болон Жаргалант сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд нь мөн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл хөгжлийн бодлоготой нийцэж байгаа хэдий ч иргэдээр хэлэлцүүлэх асуудлыг боловсруулахдаа дээрх зүйлсийг харгалзан үзээгүй байна.

Иргэдээс авсан саналын асуулт болон багуудын Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлэгдсэн асуултууд нь ерөнхий байна. Жишээ нь: гэрэлтүүлэг, зам засвар, тоглоомын талбай гэх мэт.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” болон 2014 оны 43-р тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 5.7 дахь хэсэгт заасан “Баг хорооны Засаг дарга иргэдийн Нийтийн хуралд иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, харъяа сум дүүргийн Засаг даргаас ирүүлсэн /хэрвээ байгаа бол/ хөгжлийн бодлоготой уялдуулсан төслийн санал болон хурлын явцад иргэдээс гарсан саналыг нэг бүрчлэн хэлэлцүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн авсан санал, эрэмбэ нь хууль журмын дагуу хийгдээгүй байна.

Баян-Өндөр сумын ОНХС-ийн зарцуулалтын саналыг санал асуулгын хуудсаар 2015 оны 8-аас 10 сар хүртэл “Хөгжил төв” төрийн бус байгууллагаар Баян-Өндөр сумын 10404 өрхийн саналыг авч нэгтгэн, саналын тоогоор эрэмбэлэн гаргасан байна. Энэ нь “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-н 12.2.1.б-д заасан “саналыг асуулгын хуудсаар авахад энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягыг ашиглах ба маягыг баг, хорооны айл өрх бүрт жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ” заалттай нийцэхгүй байна.

Баян-Өндөр сумын багууд Иргэдийн Нийтийн хурлаа 2015 оны 10 сард, Жаргалант сумын багууд Иргэдийн Нийтийн хурлаа 2015 оны 6 сард зохион явуулсан байгаа нь ОНХС-ийн зааврын 5.2-т заасан “Баг хорооны иргэдийн Нийтийн Хурлын дарга ирэх онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг жил бүр 5 дугаар сард багтаан зохион байгуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иргэдийн Нийтийн хуралд иргэдээс гарсан саналыг хэлэлцүүлж байгаа хэдий ч хурал дээр өгсөн иргэдийн саналыг өмнөх саналын хуудасны дүн дээр нэмж тооцсон байгаа нь “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.2.5-д заасан “сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхийн санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцална” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иргэдийн санал огт аваагүй аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр түрээсийн орон сууц худалдан авах ажилд 1241.4 сая төгрөг, Даваат багийн 280 хүүхдийн сургуулийн барилга 2 багц ажилд 1196.2 сая төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх зураг төсвийн 11 ажилд 246.9 сая төгрөг зарцуулсан буюу Орхон аймгийн ОНХС-аар хийгдсэн ажлууд нь бүгд иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй байна.

Баян-өндөр сумын ОНХС-аас иргэдийн санал аваагүй:

- Орц засварын 179.3 сая төгрөг 13 ажил,

Иргэдийн саналаар эрэмбэлэгдэн эхний 5-т жагссан ч хийгдээгүй:

- Хогийн савыг нэмэгдүүлэх
- Хороололд иргэдийн оролцоотой халуун усыг нэмэгдүүлэх
- Нэг цэгийн үйлчилгээтэй болох зэрэг саналууд байна.

Үндэсний аудитын газраас ирүүлсэн судалгааны маягтын дагуу 229 иргэдээс судалгаа авахад судалгаанд оролцогчдын 54.5% нь ОНХС-ийн талаар мэдээлэл байхгүй, 61.1% нь багийн Иргэдийн нийтийн хуралд огт оролцдоггүй, 56.3% нь ОНХС-аар хэрэгжиж байгаа санхүүжилтийн мэдээллийн талаар сонсож байгаагүй гэсэн хариу гарсан.

Судалгааны дэлгэрэнгүй дүнг ҮАГ-т хүргүүллээ.

2.3 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь заалтыг хангасан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Зураг, төсөв хийгдсэн байх шаардлагатай Баян-Өндөр сумын ОНХС-аар хийгдсэн 68 ажил, Жаргалант сумын ОНХС-аар хийгдсэн 22 ажлууд нь бүгд техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдан зураг төсвийн зардалд Баян-Өндөр сумын ОНХС-аас 79.5 сая төгрөг, Жаргалант сумын ОНХС-аас 13.1 сая төгрөг зарцуулагдсан байгаа нь “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь “Хөрөнгө оруулалт,хөтөлбөр төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх” заалтыг хангасан байна.

2.4 Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд шинээр хэрэгжүүлсэн нийт 156 төсөл, арга хэмжээний 6.5 хувь буюу 10 ажлыг нээлттэй тендер, 46.2 хувь буюу 72 ажлыг харьцуулалтын аргаар, 40.2 хувь буюу 55 ажлыг шууд гэрээ байгуулах аргаар хэрэгжүүлж, 12.1 хувь буюу 19 ажилд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй ажлууд нь ХАА зохион байгуулах шаардлагагүй буюу дараах ажлууд байна:

Аймгийн ОНХС-аар:

- Хотын захирагчийн албаар хийлгэх 13 ажлын зураг төсөв,

Жаргалант сумын ОНХС-аар:

- Малжуулах, Хөдөөгийн хот, Говийн чоно зэрэг нийт 6 хөтөлбөр байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалтыг хүснэгтээр харуулбал:

№	Аймаг, сумын нэр	Төлөвлөсөн ажил		2016 оны худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт			
		Өмнөх оноос шилжсэн	Тайлан т оны ажил	НТШ	Харьцуулалтын аргаар	ШГБ	ХАА зохион байгуулаагүй
1	Орхон		14	1			13
2	Баян-өндөр	4	102	7	61	34	
3	Жаргалант	2	40	2	11	21	6
	Нийт дүн	6	156	10	72	55	19

Баян-Өндөр сумын ОНХС-аар хийгдсэн 769.9 сая төгрөгийн Жижиг дунд үйлдвэрлэлийн бойжуулах (инкубатор) төвийн үл хөдлөх хөрөнгө худалдан авах ажиллагаанд “Неман Констракшн ХХК” нь тендерийн баримт бичигтээ “худалдан авах ажиллагааг явуулж байгаа хүмүүстэй нэгдмэл сонирхолтой болно” хэмээн бичиг ирүүлсэн боловч уг компанийг тендерт шалгаруулсан байгаа нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 14.1 “Дараахь нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ”, 14.1.5 “тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой” заалтыг зөрчсөн байна.

2.5 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүрэгт багтаагүй төсөл, арга хэмжээнд 426.2 сая төгрөг, өөр эх үүсвэртэй давхардуулан 1196.2 сая төгрөгийг тус тус ОНХС-аас зарцуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүрэгт багтсан 138 төсөл, арга хэмжээнд 6908.5 сая төгрөг зарцуулсан байна.

Тухайлбал:

- Авто зам засвар, өргөтгөл, шинэчлэл, явган хүний замын 22 ажилд 467.0 сая төгрөг,
- Гэрэлтүүлэг, цахилгааны 10 ажилд 542.9 сая төгрөг,
- Барилга, засварын 39 ажилд 1289.5 сая төгрөг,
- Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, засварын 3 ажилд 294.1 сая төгрөг зэргээр чиг үүрэгт тохирсон ажлуудад санхүүжилт олгон гүйцэтгүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 7-р бүлэг “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргүүд”-д багтаагүй дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Орхон аймгийн ОНХС-аас Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын зураг төсвийн 11 ажилд 246.9 сая төгрөг,

- Баян-Өндөр сумын ОНХС-аас орц засварын 13 ажилд 179.3 сая төгрөг нийт 426.2 сая төгрөгийг зарцуулсан зөрчилтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 4.8 “ОНХС-аас зарцуулах эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй давхардуулахгүй байх” заалтыг зөрчин аймгийн ОНХС-аас Орон нутгийн хөрөнгө оруулалттай давхардуулан Даваат багийн 280 хүүхдийн сургуулийн барилгын ажилд 1196.2 сая төгрөгийг давхардуулан зарцуулсан зөрчилтэй байна.

2.6 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг тавьж, ажлын гүйцэтгэл болон гэрээний заалтыг баримтлан санхүүжилтийг олгосон байна.

2016 онд ОНХС-аас хийгдсэн санхүүжилтийн мэдээлэл

№	Аймаг, сумын нэр	Өмнөх оны үлдэгдэл	2016 онд нэмэгдсэн	Зарцуулсан	/сая төгрөг/
					Үлдэгдэл
1	Орхон	25.3	2859.6	2508.3	376.6
2	Баян-өндөр	93.6	3717.1	3585.3	225.4
3	Жаргалант	2.2	1244.0	1241.1	5.1
	Нийт дүн	121.1	7820.7	7334.7	607.1

ОНХС-ийн хөрөнгөөр өмнөх оноос шилжсэн 622.5 сая төгрөгийн 6 ажил, 2016 онд шинээр төлөвлөсөн 7376.7 сая төгрөгийн 156 төсөл, арга хэмжээг хийж гүйцэтгэсэн байна. Хүснэгтээр харуулбал:

№	Аймаг, сумын нэр	Өмнөх оноос шилжсэн		Шинэ оны ажил	
		тоо	дүн сая/төг	тоо	дүн сая/төг
1	Орхон			14	2853.7
2	Баян-өндөр	4	270.5	102	3637.1
3	Жаргалант	2	352.0	40	885.9
	Нийт дүн	6	622.5	156	7376.7

Аймгийн хэмжээнд 2016 онд шинээр хийгдсэн 156 ажил бүрэн хийгдэж дууссан байна.

Өмнөх оноос шилжин хийгдсэн дараах ажлууд байна.

Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр:

- 86.3 сая төгрөгийн 2013 оны дээврийн ажлын санхүүжилт,
- 78.2 сая төгрөгийн Хотын камержуулалт,
- 78.7 сая төгрөгийн Байр хоорондын гэрэлтүүлэг, Согоот баг,
- 27.3 сая төгрөгийн Баян-Өндөр сумыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах ажлын зардлын төлөвлөгөө,

Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр:

- 350 сая төгрөгийн Спорт залыг барьж дуусгах ажил,
- 2.0 сая төгрөгийн Агро паркийн худгын насосын ажил байна.

Эдгээр ажлуудаас 2013 онд хийгдсэн боловч тухайн үед чанаргүй, дутуу хийгдсэн Женекон ХХК-ны гүйцэтгэсэн 86.3 сая төгрөгийн дээвэр засварын ажил нь маргаантай шүүхийн шатанд байгаа шалтгаанаар хийгдээгүй, бусад ажил нь бүрэн хийгдэж санхүүжилтээ авсан байна.

Орон нутгийн оролцоотой, иргэдийн бүлгээр Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 499.2 сая төгрөгийн 36 ажил, Жаргалант суманд 71.7 сая төгрөгийн 10 ажил хийгдсэн байна. Тухайлбал:

Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр:

- 75.0 сая төгрөгөөр ногоон байгууламж, тохижилтийн 4 ажил,
- 179.3 сая төгрөгөөр орц засварын 13 ажил,
- 38.6 сая төгрөгөөр үерийн сувагт хоолой тавих 2 ажил,
- 206.2 сая төгрөгөөр явган хүний зам, шат, гүүрийн 16 ажил,

Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр:

- 43.5 сая төгрөгөөр зам засварын 4 ажил,
- 21.7 сая төгрөгөөр барилга засварын 4 ажил,
- 6.5 сая төгрөгөөр тоног төхөөрөмжийн засварын 2 ажил хийгдсэн байна.

Иргэдийн бүлгээр ажил хийлгэх гэрээнд хариуцлагын талаар тусгаж өгөөгүй байдаг нь хийгдсэн ажил чанаргүй болох, ямар нэгэн эвдрэл гарсан тохиолдолд хариуцах эзэнгүй болох магадлал их байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээнд дутуу болон чанаргүй хийгдсэн дараах ажлууд байна.

Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр:

- 10 сая төгрөгийн санхүүжилттэй Хүрэнбулаг, Зэст багийн иргэний танхимын тохижилтийн ажилд гэрээнд заасан үзүүлэлтэд хүрэхгүй хуучин нөтбүүк нийлүүлсэн ажлыг аудитын явцад шинэ нөтбүүкээр солиулсан,
- 9 сая төгрөгийн санхүүжилттэй 15-р цэцэрлэгт зөөлөн эдлэл нийлүүлэх ажлын гэрээнд “Эрдэнэт хивсний хөнжил нийлүүлнэ” гэж заасан боловч гэрээнд заагаагүй хятад хөнжил нийлүүлсэн ажилд акт бичсэн,
- 179.3 сая төгрөгийн санхүүжилттэй 13 багц орцны засварын ажил чанаргүй хийгдсэн ажлыг хуулийн байгууллагад шилжүүлэхээр болсон. Чанаргүй хийгдсэн 5.5 сая төгрөгийн ажилд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.


Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр:

- 58.8 сая төгрөгний санхүүжилттэй Жаргалант сумын орон сууцнуудын 12,13,14-р байрнуудын дээврийг сэргээн засварлах ажилд гүйцэтгэгч байгууллагад акт бичсэн.

Жаргалант сумын 12-р байрны дээвэр



15-р цэцэрлэгт нийлүүлэгдсэн хятад хөнжил



Зэст багт нийлүүлэгдсэн байсан хуучин нөтбүүк



1-5-р байрны засвар хийсэн орц

Дутуу болон чанаргүй гүйцэтгэсэн ажлуудад хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Эдгээр төсөл, арга хэмжээнээс бусад төсөл, арга хэмжээнүүд бүрэн, чанартай хийгдсэн байна.

ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг ХББЗА-ОНӨҮГ болон ХЗАлбатай гэрээ байгуулан, олон нийтийн оролцоотой ажлуудад ЗДТГ-аас томилсон ажлын хэсэг давхар үе шатны хяналтыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Олон нийтийн оролцоотой ажилд Жаргалант сум нь мэргэжлийн байгууллагаар үе шатны хяналт тавьж ажиллахад хүндрэлтэй байдаг тул сумын ЗДТГ-аас байгуулсан ажлын хэсэг үе шатны хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж, захиалагчийн хяналт гүйцэтгэсэн нь ЗГ-н 2009 оны 73-р тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.5-д заасан заалттай нийцэж байна.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч ХББЗА ОНӨҮГ болон ХЗА-тай байгуулсан гэрээний дагуу захиалагчийн хяналтын зардлыг холбогдох нормоор тооцон, суутгаж

тооцоолсон бөгөөд аймгийн ОНХС-аас 6.9 сая төгрөг, Баян-Өндөр сумын ОНХС-аас 79.5 сая төгрөг, Жаргалант сумын ОНХС-аас 13.1 сая төгрөгийг олгожээ.

2.7 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн дагуу бүртгэл тайланд тусгасан байна.

ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг аймаг, сумын ХАААлба, ХББЗА ОНӨҮГ-ийн гүйцэтгэлийн жагсаалт, СТСХ-ийн санхүүжилт олгосон жагсаалтаар аймгийн ӨХГ-т хүргүүлж, аймгийн Өмчийн харилцааны газрын болон ашиглагч байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүртгэх ёстой 5988.2 сая төгрөгийн 129 хөрөнгийг 100% бүртгэж ажилласан байна. Үүнд:

- Орхон аймгийн ОНХС-аар хийгдсэн 2000.0 сая төгрөгийн 1 хөрөнгө,
- Баян-Өндөр сумын ОНХС-аар хийгдсэн 3330.9 сая төгрөгийн 96 хөрөнгө,
- Жаргалант сумын ОНХС-аар хийгдсэн 657.3 сая төгрөгийн 32 хөрөнгө багтаж байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага биелж, улмаар энэ онд өмчийн бүртгэл, тайлагнал сайжирсан байна.

Бүлэг. 3 ОНХСангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаагүй байна.

3.1. ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэний нийгмийн байгууллагууд болон дотоод аудитын алба ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

2016 онд Орхон аймагт ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо гэж ажиллаагүй байна.

Энэ нь ОНХС-ийн зааврын 9.1-т заасан “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана” заалттай нийцэхгүй байна.

Дотоод аудитын алба болох Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, Жаргалант сумын ОНХСангийн 2016 оны эхний хагас жилийн худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийхээр төлөвлөн аймгийн Засаг даргаар удирдамж батлуулан аймгийн Худалдан авах ажиллагаанд албан бичиг хүргүүлсэн боловч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн эрхтэй албан тушаалтан хяналт шалгалт хийх эрхтэй танай дотоод аудитын алба худалдан

авах ажиллагаанд хяналт, шалгалт хийх эрхгүй гэсэн хариуг ХАААлба өгч тендерийн баримт материалыг ирүүлээгүй тул аудитыг хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.2-т заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, ОНХС-ийн зааврын 9.2-т “ОНХС-аас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

3.2. ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу хүргүүлээгүй, тайланд дүн шинжилгээ хийгээгүй байна.

Сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн тайлангууд аймгийн СТСХ-ийн ажилтанд, уг ажилтан нь Сангийн яаманд хэрэгжилтийн тайлангаа явуулдаг ба Засаг даргын захирамжаар хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх ажлын хэсэг томилж ажиллаагүй, Хөгжлийн бодлогын хэлтсийн хамаарах ажлыг тухайн СТСХ гүйцэтгэж байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43-р тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1-т “Сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг жил бүрийн 7 сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томируулж ажиллуулна”, 10.2-т “Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум, дүүрэг бүрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулах шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 2 дугаар сарын 25-ны дотор хэлэлцүүлнэ”, 10.3-т “Аймаг, нийслэл ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, гарсан санал зөвлөмжийн хамт жил бүрийн 3 дугаар сарын 10-ны дотор Сангийн яамны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтэст ирүүлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн мэдээллийг зааврын дагуу мэдээлээгүй байна.

Орхон аймгийн ОНХС-ийн санхүүжилтийн мэдээг СТСХ нь мэдээллийн самбараар мэдээлж ажилласан байна.

Баян-Өндөр, Жаргалант сумын ОНХС-ийн санхүүжилтийн мэдээг зааврын дагуу ЗДТГ-ын мэдээллийн самбарт тухай бүр, байршуулж мэдээлээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43-р тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 11.2.3-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь тухайн орон нутагт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд тогтмол мэдээлэх бөгөөд бөгөөд санхүүжилт хийгдэх тухай бүр мэдээллийг шинэчилж байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.4 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байна.

Аудитын явцад ашигласан хууль, тогтоомж, заавар, журмуудаас Орон нутгийн хөгжлийн сангийн заавартай зөрчилдөх хууль тогтоомж байгаагүй болно.

3.5. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж 100 хувь, албан шаардлага 90.1 хувийн биелэлттэй байна.

Өмнөх аудитаар 4 зөвлөмж, 11 албан шаардлага өгөгдсөнөөс зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай, албан шаардлагын хэрэгжилт 90.1%-тай байна.

Албан шаардлагын биелэлт:

№	Албан шаардлагын утга	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй
1	Концессийн гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж батлуулсан.	2016 оны ОНХСангийн хөрөнгөөр концессийн гэрээгээр ажил гүйцэтгүүлээгүй байна.	
2	Аймгийн баяр наадмын зардлыг бусад эх үүсвэртэй давхардуулж төлөвлөсөн.	Хөгжлийн бодлогын хэлтсээс баяр наадмын зардлыг давхардуулж төлөвлөөгүй байна.	
3	ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөхдөө зураг төсвийн зардлыг багцалсан дүнгээр төлөвлөсөн. /Хөгжлийн бодлогын хэлтэс/	2016 оны ОНХСангийн хөрөнгөөр зураг төсвийн зардлыг багцалсан дүнгээр төлөвлөөгүй.	
4	ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөхдөө зураг төсвийн зардлыг багцалсан дүнгээр төлөвлөсөн. /Хотын захирагчийн алба/	2016 оны ОНХСангийн хөрөнгөөр зураг төсвийн зардлыг багцалсан дүнгээр төлөвлөөгүй.	
5	Концессийн гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд ОНХС-аас 929.3 сая төгрөгийн санхүүжилт	Концессийн гэрээгээр	

	олгосон.	<i>гүйцэтгүүлсэн ажилд санхүүжилт олгоогүй.</i>	
6	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 27.1 сая төгрөгийн 3 ажлын зураг төсвийг боловсруулах зардлыг санхүүжүүлсэн.		<i>2016 онд 246.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон зөрчилтэй байна.</i>
7	ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон нийтийн эзэмшлийн 156.8 сая төгрөгийн хөрөнгө, хөрөнгө бэлтгэгдсэн байгууллагууд бүртгэлд аваагүй 996.3 сая төгрөг нийт 1153.1 сая төгрөгийг ашиглагч байгууллагын хөрөнгөд бүртгүүлээгүй.	<i>Аймгийн өмчийн харилцааны газар эдгээр хөрөнгүүдийг ашиглагч байгууллагын хөрөнгөд бүртгүүлсэн.</i>	
8	Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 5 ажлын баталгаат хугацаа дуусаагүй байхад эвдэрч гэмтсэн.	<i>Эвдэрч гэмтсэн ажлуудыг засаж сэлбэсэн.</i>	
9	Малжуулах хөтөлбөрөөр иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгогдож буй 27.3 сая төгрөгийн малыг Жаргалант сумын ОНХС-ийн тайланд авлагаар бүртгээгүй, Орон нутгийн санхүүгийн нэгдсэн тайланд тусгаагүй.	<i>Тайланд бүртгэж тусгасан.</i>	
10	Сумын тодорхой цэгийн камержуулах ажлыг 2015 оны 04-р сарын 27-ны өдрөөс 2015 оны 05-р сарын 15-ны өдөр гүйцэтгэх байтал 2015 оны 10-р сарын 12-ны өдөр ажлыг гүйцэтгэж хүлээлгэж өгсөн байна. Гэрээний дагуу уг ажилд хугацаа хэтэрсэн 150 хоногийн 1.5 сая төгрөгийн алданги тооцоогүй санхүүжилтийг 100 хувь олгосон.	<i>Зөрчил давтагдаагүй.</i>	
11	Олон нийтийн оролцоотой ажилд хяналт тавьсан мэргэжилтэнтэй хяналт хэрэгжүүлэх гэрээ байгуулалгүй хурлын протокол болон Засаг даргын захирамжийг үндэслэн харилцах дансруу нь 0.7 сая төгрөгийг шилжүүлсэн.	<i>Зөрчил давтагдаагүй.</i>	

Аудитаар нийт 67.7 сая төгрөгний 2 акт, 431.7 сая төгрөгний 3 албан шаардлага, 20 зөвлөмж өгөгдлөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн “ОНХС-ийн төлөвлөлтийг хийхдээ төсөл арга хэмжээг иргэдэд нээлттэй хэлэлцүүлэн санал авч эрэмбэлээгүй, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаагүй байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

- ОНХС-н хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөөгүй ч хуулийн дагуу бүрдүүлж, хуваарилсан байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөн баталж, гүйцэтгээгүй байна.
- ОНХСангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-д:

- Сангийн сайдын 2014 оны 43-р тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1-т заасны дагуу Хяналтын хороо байгуулан хяналт тавьж ажиллах.

Аймгийн Засаг даргад:

- Төсвийн тухай хуулийн 14.2.10, Сангийн сайдын 2014 оны 43-р тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.2-т заасны дагуу Дотоод аудитын албаар ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх,
- Сангийн сайдын 2014 оны 43-р тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 6-д заасан “Аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөх” заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн ЗДТГ-т:

- ТБОНӨХБАҮХАТХуулийн 47.4 дэх заалтыг ханган Үнэлгээний хорооны ил тод байдлыг хангаж ажиллах,

Хөгжлийн бодлогын хэлтэст:

- Сангийн сайдын 2014 оны 43-р тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1, 10.2, 10.3 дэх заалтуудын дагуу ОНХС-ийн тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийн Сангийн яаманд хүргүүлж ажиллах,
- 2014 оны 43-р тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг мөрдөж ажиллах, хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйгээр хангах.

Санхүү төрийн сангийн хэлтэст:

- Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал

ҮАГ-НАГ/2017/01-НА/ОААГ

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу ОНХС-ийн орлого, эх үүсвэрийн төлөвлөлтийг хийж байх,

- Орон нутгийн хөгжлийн сангаас сумдад олгох санхүүжилтийг Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан аргачлалаар тооцон хуваарилж байх.

Баян-Өндөр, Жаргалант сумдын ИТХ-д:

- Сангийн сайдын 2014 оны 43-р тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1-т заасны дагуу Хяналтын хороо байгуулан ажиллах.

Баян-Өндөр, Жаргалант сумын Засаг даргад:

- Сангийн сайдын 2014 оны 43-р тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 5-д заасан “Сум,дүүргийн түвшинд ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөх” заалтыг хэрэгжүүлж ажиллах.


Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ-т:

- Сангийн сайдын 2014 оны 43-р тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 11.2.3-т заасны дагуу санхүүжилтийн мэдээг мэдээллийн самбарт тухай бүр байршуулж байх,
- Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах,
- ТБОНӨХБАҮХАТХуулийн 47.4 дэх заалтыг ханган Үнэлгээний хорооны ил тод байдлыг хангаж ажиллах,
- Иргэдийн бүлгээр ажил хийлгэх гэрээнд хариуцлагын талаарх заалтыг тодорхой болгох, явцын хяналтыг сайжруулах.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ  Д.ЦОГБАДРАХ
ШИНЖЭЭЧ  О.ДАШЖАМЦ

Хавсралт № 1

Нийцлийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

/ сая төгрөгөөр/

Д/Д	Зөрчлийн товч утга	Зөрчил хариуцагч байгууллага	хариуцагч		Зөрчил	Алдаа
			Албан тушаал	Нэр		
02/83	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөс иргэдийн саналаар дэмжигдээгүй, орон нутгын хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийг хийсэн.	СТСХ	Дарга Мэргэжилтэн	Н.Бямбацэцэг Н.Баясгалан		246.9
01/82	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнөөс иргэдийн саналаар дэмжигдээгүй, ОНХС-ийн зааврыг зөрчиж зориулалт бусаар зарцуулсан.	Баян-Өндөр сумын Засаг дарга, Санхүүгийн алба	Засаг дарга Санхүүгийн албаны дарга	С.Ганцогт Б.Ган-эрдэнэ		179.3
03/84	Дутуу болон чанаргүй хийгдсэн ажлыг хийж дуусгах.	Баян-Өндөр сумын ЗДТГ	Дарга Мэргэжилтэн	М.Эрдэнэчимэг Д.Сүнжидмаа		5.5
01/38	Чанаргүй хийгдсэн дээврийн ажлыг хийж дуусгах.	Богатырь ХХК	Захирал	Б.Мөнхгэрэл	58.7	
02/39	Гэрээний дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлээгүй.	Хос монтаж ХХК	Захирал	С.Эрдэнэболд	9.0	
Нийт дүн					67.7	431.7

Акт, албан шаардлагыг хариуцагч байгууллагуудад эх хувиар хүргүүлсэн, зөрчлийг дэлгэрэнгүй тайланд тусгасан.